



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/517

Есөнбулаг

┌ Ээлжит цэрэг татлага явуулах ┐  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2023 оын мн/190 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн жинхэнэ албаны 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг аймгийн хэмжээнд 10 дугаар сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 19-ний өдрүүдэд явуулсугай.

2.2023 оны хоёрдугаар ээлжийн Цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

|                                |                        |  |
|--------------------------------|------------------------|--|
| Цэрэг татлагын товчооны дарга: | Ш.Эрдэнэбат            | (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)                               |
| Орлогч дарга:                  | хурандаа Д.Төмөрбаатар | (Цэргийн штабын дарга)   |
| Гишүүд:                        | хурандаа Н.Мэндбаяр    | (Цагдаагийн газрын дарга)  |
|                                | Г.Лхагважаргал         | (Эрүүл мэндийн газрын дарга)   |
|                                | Д.Сэлэнгээ             | (Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)            |
|                                | Ж.Уранчимэг            | (Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
|                                | Г.Цэдэв                | (Цэргийн штабын офицер)  |
|                                | Г.Баасанцог            | (Цэргийн штабын офицер)  |
| Нарийн бичгийн дарга:          | Г.Мөнхбаяр             | (Цэргийн штабын офицер)  |

3.Сум орон нутагтаа цэрэг татлагын ажлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулан цэрэг татлагын байрыг бэлтгэх, 18-26 насны цэргийн үүрэгтнүүдийг бүрэн хамруулах, Засгийн газрын 2023 оны 119 дугаар тогтоолын дагуу цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн албыг мөнгөн төлбөрөөр орлуулан хаах болзол хангасан иргэдийг цэрэг татлагын байранд байлгах, иргэний хувийн бичиг баримт, иргэний үнэмлэхийг бүрдүүлж тогтоосон хугацаанд бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор баталсан "Иргэнийг цэргийн албанд эрүүл мэндээр тэнцүүлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.2.1 дэх заалтын дагуу цэргийн албанд татагдаж байгаа иргэдийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, цэрэг татлагын байранд авч ирэх, эрүүл мэндийн үзлэгт сумдын Эрүүл мэндийн төвийн шаардлагатай эмч, сувилагч нарыг

C:\Documents\ ZD A-4 doc

байлцуулах, 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын товчоогоор эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэх талаар авсан арга хэмжээг илтгэх хуудсаар танилцуулах, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг сахиж ажиллахыг сумдын Засаг дарга, сум дундын эмнэлэг болон сумдын Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Цэргийн албанд татагдаж байгаа иргэдийг Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын дагуу үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлэн ажиллах тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж, тайланг 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар хэлэлцүүлэхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Нэгдсэн эмнэлэг (Д.Сэлэнгээ)-т тус тус хариуцуулсугай.

6.Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2023 онд хэрэгжүүлэх гэрээний 2 дугаар заалтын 2.8, 5 дугаар заалтын 5.3 дахь хэсгийн дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбарын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, Хилийн цэргийн 0214 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдыг эргэх ажил зохион байгуулахыг Цэрэг татлагын товчоо (Ш.Эрдэнэбат), Цэргийн штаб (Д.Төмөрбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

7.Цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, зарлан дуудах мэдэгдэл аваад тогтоосон хугацаанд заасан байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг цэрэг татлагын байранд ирүүлэх ажлыг сумын хэсгийн төлөөлөгч нараар дамжуулан зохион байгуулж, цэрэг татлагын үед архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар (Н.Мэндбаяр)-т даалгасугай.

8.Гэмт хэргийн холбогдлоор шалгагдаж байгаа болон мансууруулах бодисын хамааралтай энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлөх бодис тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг, мансуурах донтой болох нь тогтоогдсон иргэнийг цэргийн албанд татахгүй байхыг цэрэг татлагын товчоо (Ш.Эрдэнэбат), цэргийн албанд тэнцсэн иргэдийг тээвэрлэх явцад хяналт тавих, техникийн бэлэн байдлыг хангуулан ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Н.Мэндбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

9.Цэрэг татлагын товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, сумдын цэрэг татлагаар орох хуваарийг гуравдугаар хавсралтаар, зарцуулах хөрөнгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

10.Цэрэг татлагын үйл ажиллагаанд шаардагдах зардал 34,210,800 ( гучин дөрвөн сая хоёр зуун арван мянга найман зуу) төгрөгийг цэрэг татлагын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

11.Цэргийн жинхэнэ албаны 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага явуулсан дүн мэдээг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт тус тус хүргэж ажиллахыг Цэргийн штаб (Д.Төмөрбаатар)-т, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг цэрэг татлагын товчоо (Ш.Эрдэнэбат)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

ЦЭРЭГ ТАТЛАГЫН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

1. Цэрэг татлагын товчооны дарга: Ш.Эрдэнэбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
  - а. Цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангуулж, цэрэг татлагын ажиллагааг удирдах,
  - б. Товчооны гишүүдийг зохих үүргээр ханган, гишүүд үүргээ шударгаар биелүүлж байгаад хяналт тавих.
  - в. Товчооны гишүүдэд шаардагдах байр, хоол, томилолт, унааны зардлыг шийдвэрлэж өгөх.
  - г. Цэргийн албанд тэнцэгчдийг жинхэнэ алба хаалгах шийдвэр гаргаж, цэргийн анги салбарт хуваарилах ажилд хяналт тавих.
  - д. Цэрэг татлагын ажлын дүнг аймгийн Засаг даргад танилцуулах
2. Орлогч дарга: Хурандаа Д.Төмөрбаатар (Цэргийн штабын дарга)
  - а. Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах.
  - б. Иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх.
  - в. Хугацаат цэргийн албан хаагчдыг хуваарилагдсан анги салбарт нь хүргэж өгөх.
3. Нарийн бичгийн дарга: хошууч Г.Мөнхбаяр (Цэргийн штабын офицер)
  - а. Цэрэг татлагын ажлын урьдчилсан бэлтгэлийг хангах,
  - б. Цэрэгт татагдагчдын баримт бичгийг бүрдүүлэх, баримт бичигт бичилт хийх,
  - в. ЗХЖШ, ХХЕГ- т явуулах мэдээ тайланг гаргаж хүргэх,
4. Гишүүн: хурандаа Н.Мэндбаяр (Аймгийн Цагдаагийн газрын дарга)
  - а. Цэрэг татлагын үед цэрэг татлагын байранд цагдаагийн жижүүр гарган ажиллуулах, хяналт тавих.
  - б. Дэлгүүр, олон нийтийн үйлчилгээний газруудад согтууруулах ундааны зүйл худалдаалах үйл ажиллагаанд хяналт тавих,
  - в. Цэрэг халах, үдэн гарах үед хэв журам сахиулах хүч нэмэгдүүлсэн эргүүл гарган ажиллуулах.
5. Гишүүн: Г.Лхагважаргал (Эрүүл мэндийн газрын дарга)
  - а. Сумдын эрүүл мэндийн газруудад цэргийн жинхэнэ албанд татагдаж байгаа иргэдэд Засагийн газрын 2017 оны 144 тогтоолын дагуу үзлэг шинэжилгээ хийх боломж нөхцлийг хангах.
5. Гишүүн: Д.Сэлэнгээ (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)
  - а. Эмч нарын комиссыг удирдан эмч нарт зааварчилгаа өгөх, Засгийн газрын 2017 оны 144 тогтоол, иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журмыг мөрдлөгө болгон ажиллах.
6. Гишүүн: Ж.Уранчимэг (Биеийн тамир, спортын газрын дарга)
  - а. Цэрэг татлагын байрыг бэлтгэж ажиллах нөхцөлөөр хангах
7. Гишүүн: дэд хурандаа Г.Цэдэв (Цэргийн штабын офицер)
  - а. Цэрэг халах, үдэн гаргах ажлыг зохион байгуулах
  - б. Халагдаж ирсэн дайчдыг хүлээн авах бичиг баримтыг нь хүлээлгэн өгөх
8. Гишүүн: дэд хурандаа Г.Баасанцог (Цэргийн штабын офицер)
  - а. Цэрэг татлагын ажлын урьдчилсан бэлтгэлийг хангах
  - б. Цэрэг татлагын товчооны дотоод хэв журмыг хангах

Аймгийн Засаг даргын 20 09 оны  
09 дугаар сарын 20-ны өдрийн 407 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ ЭМЧ  
НАРЫН НЭРС

| №  | Нэрс          | Ямар мэргэжлийн үзлэг явуулах                                 |
|----|---------------|---|
| 1  | Л.Отгончимэг  | Ерөнхий эмч (Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал) |
| 2  | Г.Алзахгүй    | Гэмтэл, Мэс заслын эмч  |
| 3  | Ш.Юмжирмаа    | Мэдрэлийн эмч   |
| 4  | Х.Аззаяа      | Чих хамар хоолойн эмч   |
| 5  | П.Булагмаа    | Арьс харшил   |
| 6  | Д.Оюунтамир   | Дотрын эмч  |
| 7  | Т.Хаш-Эрдэнэ  | Нүдний эмч (сувилагч)   |
| 8  | П.Нямцэрэн    | Сүрьеэгийн эмч  |
| 9  | А.Наранбаяр   | Техникч   |
| 10 | О.Нямхүү      | Эхо   |
| 11 | Г.Батбаяр     | Шүдний эмч  |
| 12 | Л.Чулуунхишиг | Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн                              |
| 13 | Д.Дэлгэр      | Сувилагч лаборант   |

\_\_оОо\_\_



Аймгийн Засаг даргын 20<sup>23</sup> оны  
09 дугаар сарын 10-ны өдрийн А/577 дугаар  
захирамжийн гуравдугаар хавсралт

СУМДЫН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООГООР  
ОРОХ ХУВААРЬ

| №  | Сумдын нэрс  | Хяналтын тоо   | Орох он сар өдөр | Орох цаг                   |
|----|--|--|------------------|----------------------------|
| 1  | Есөнбулаг  | 18-26 насны II зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг бүрэн хамруулах /ХАӨМС-тай тулгаж гаргах/ | 2023.10.02       | 09.00-15.00                |
| 2  | Тайшир   |  | 2023.10.03       | 09.00-12.30<br>15.30-17.00 |
| 3  | Жаргалан   |  | 2023.10.04       | 09.00-12.30                |
| 4  | Баян-Уул   |  |                  | 16.30-18.00                |
| 5  | Хөхморьт   |  | 2023.10.05       | 09.00-12.30                |
| 6  | Дарив  |  |                  | 16.00-18.30                |
| 7  | Тонхил   |  | 2023.10.06       | 09.00-11.30                |
| 8  | Төгрөг   |  |                  | 16.00-18.00                |
| 9  | Бугат  |  | 2023.10.07-08    |                            |
| 10 | Яргайт, Элгэний заставт  |  |                  |                            |
| 11 | ЗХ-ний 304 тусгай Салбарын алба хаагчдыг ЭМ-ийн үзлэгт хамруулах |  | 2023.10.09       | 16.00-18.30                |
| 12 | Алтай (Замын шандын застав)                                      |  | 2023.10.10       | 09.00-11.30                |
| 13 | Цогт   |  | 2023.10.11       | 09.00-11.30                |
| 14 | Цээл   |  |                  | 16.30-18.00                |
| 15 | Халиун   |  | 2023.10.12       | 09.00-11.30                |
| 16 | Бигэр  |  |                  | 16.30-18.00                |
| 17 | Эрдэнэ   |  | 2023.10.13       | 09.00-11.00                |
| 18 | Чандмана   |  |                  | 16.30-18.00                |
| 19 | Дэлгэр   |  | 2023.10.14       | 08.30-10.30                |
| 20 | Шарга  |  | 2023.10.15       | 08.30-15.30                |

- Жич: 1.Сумын эмнэлэг бие бялдар үзэх жин, эхо аппарат бэлдэх  
2.2023 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар зарим сумд эрүүл мэндийн үзлэгийн урьдчилсан шинэжилгээ хийгээгүй дутагдал гарсан тул дахин гаргахгүй байхыг анхааруулъя.  
3.Цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийг цэрэг татлагын байранд байлгах

\_\_оОо\_\_

Аймгийн Засаг даргын 20<sup>20</sup> оны  
 01 дугаар сарын 10-ны өдрийн А/59 дугаар  
 захирамжийн дөрөвдүгээр хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

ДУГААР 2

| №  | Зарцуулах зүйлийн нэр   | Хүний болон материал хэрэгслийн тоо хэмжээ, /км, хоног/ | Зардал   | Нийт зардал                |
|----|---|---|--|----------------------------|
| 1  | Комиссын бүрэлдэхүүн хоол, зардал (өдөрт 1 удаа 2 хоног)  | 36 хүн 2 өдөр<br>1,2 хоол, цай                          | 36*2*25000   | 1,800,000 ✓                |
| 2  | Хилийн цэргийн 0214 дүгээр ангид хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдаа иргэх Засаг даргын талархал гардуулах /Застаат дурсгалын зүйл бэлдэх 3ш/ | Цэрэг 75<br>Дурсгалын зүйл                              | 75*25000<br>3*800,000                                  | 1,875,000 ✓<br>2,400,000 ✓ |
| 3  | Засаг даргын талархал хэвлүүлэх   | 79 ш  | 300,000  | 300,000 ✓                  |
| 4  | Илүү цагаар ажиллах эмч, лаборант нарын цалинд  | 1*6000  | 10*3*6000  | 180,000 ✓                  |
| 5  | Цэргийн албанд татагдсан үүрэгтнүүдэд цээжний рентген хийлгэх   | 200 хүн   | 200*2500   | 500,000 ✓                  |
| 6  | Цэрэг хүргэж ирсэн офицёр ахлагч нарын байр хоолны зардалд  | 8 хүн 3 хоног<br>/4 өрөө/                               | 3*4*75000  | 900,000 ✓                  |
| 7  | Цэргийн бэлтгэл үүрэгтний тооцооны хуудас, бүртгэлийн карт хэвлүүлэх  | 1500 ш  | 1500*600   | 900,000 ✓                  |
| 8  | Бичиг хэргийн зардал  | Принтерийн хор 2ш                                       | 2*70000  | 140,000 ✓                  |
|    |   | Бичгийн цаас 3 боодол                                   | 3*20000  | 60,000 ✓                   |
|    |   | Цаасны цавуу 12 ш                                       | 12*1200  | 14,400 ✓                   |
|    |   | Тараах материал хэвлүүлэх гарын авлага (6 төрөл)        | 6*350=210<br>0 ш*850                                   | 1,785,000 ✓                |
|    |   | Цэрэг татлагын байрын хаяг /гадна, дотор/               | 6х8 м <sup>2</sup> *14000<br>6х8 м <sup>2</sup> *14000 | 1,344,000 ✓                |
| 9  | Бусад зардал  |   |  | 500,000 ✓                  |
| 10 | Бүгд  |   |  | 12,698,400 ✓               |

Шатахуун, томилолтын зардал

|   |  |                 |                      |              |
|---|--|-----------------|----------------------|--------------|
| 1 | Цэрэг татлагын товчооны гишүүд, эмч нарын томилолт (сумдаар явах)                            | 16 хүн 12 өдөр  | 16*12*64000          | 12,288,000 ✓ |
| 2 | Сумдаар явах шатахууны зардал (2 машин)  | 2435 км-487 л   | 487л*3350            | 1,631,450 ✓  |
|   |  | 2435 км-487 л   | 487л*33500           | 1,631,450 ✓  |
| 3 | Цэрэг татлагын товчооны дарга сумдад ажиллах шатахууны зардал                                | 1600км -320 л   | 320л*2680            | 912,000 ✓    |
| 4 | Баянхонгор, Өвөрхангай, Улаанбаатар хотод цэрэг, мэдээ тайлан хүргэх машины шатахууны зардал | 2450 км – 490 л | 490л*3350            | 1,641,500 ✓  |
| 5 | Улаанбаатар хотод цэрэг хүргэх, мэдээ тайлан өгөх 3 хүний томилолт                           | томилолт        | 3 хүн 8 хоног*142000 | 3,408,000 ✓  |
|   | Бүгд   |                 |                      | 21,512,400 ✓ |



